

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хилийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой худалдааг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/71/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn Аудитын менежер П.Чанцалдулам Утас: 261885 Цахим хаяг: chantsaldulamp@audit.gov.mn Аудитор Г.Тэлмүүн Утас: 261740 Цахим хаяг: telmuung@audit.gov.mn Гэрээгээр гүйцэтгэсэн: Бэйкер Тилли Далайван Аудит ХХК Захирал Ц.Жигдэн Утас: 70005401 Цахим хаяг: info@btdalaivanaudit.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	2
2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	5
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	8
3 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Төсөл хэрэгжүүлэх нэгж, түүний үйл ажиллагаа	10
3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл.....	13
4 АУДИТЫН ТАЙЛАН	15
4.1 Ерөнхий зүйл.....	15
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5 АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Албан шаардлага	18
5.2 Зөвлөмж	19
6 АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	21
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл.....	21
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл.....	21

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АНУ	Америкийн нэгдсэн улс
БЖДҮ	Бичил жижиг дунд үйлдвэрлэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХК	Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

ХИЛИЙН ҮР АШГИЙГ НЭМЭГДҮҮЛЖ
ТОГТВОРТОЙ ХУДАЛДААГ ДЭМЖИХ
ТӨСЛИЙН ЗАХИРАЛ Б.ТАВИНЖИЛ
ТАНАА

2026.04.10 № 06/1054
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хилийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой худалдааг дэмжих төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн дараах залруулагдаагүй 74,489.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 56,901.2 мянган төгрөгөөр давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- АНУ-ын Вашингтон хотноо Дэлхийн банк, валютын сангийн жилийн уулзалтад оролцохоор эрх бүхий 2 албан тушаалтны онгоцны тийзийн төлбөрт 32,790.0 мянган төгрөгийг албан ёсны урилга, дээд газрын тушаал шийдвэргүйгээр гадаад томилолтын зардлаас гаргасан бөгөөд ажлын тайлан, онгоцны тийзийг хавсаргаагүй;
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн 23,714.3 мянган төгрөгийг цалингийн зардалд буруу бүртгэж тайлагнасан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.7, 20 дугаар зүйлийн 20.2.9 дэх заалт, Төсвийн тухай хуулийн

1526141502

5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.5, 22 дугаар зүйлийн 22.1, 22.2.3-т заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус төсөл хэрэгжүүлэгч нэгжийн зээл, тусламж нь 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрөөс хүчин төгөлдөр болж, төсөл хэрэгжиж эхэлсэн бөгөөд тайлант онд 342.0 мянган ам.доллар буюу 1,225,806.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төсөл хэрэгжүүлэгч нэгж Дорнод аймгийн Хавирга боомтын өргөтгөл шинэчлэлийн ажлыг 2025 онд эхлүүлж 2027 онд дуусгахаар төлөвлөсөн байна. Монгол Улсын Засгийн газар, Азийн Хөгжлийн Банктай байгуулсан гэрээнд уг боомтын 85 км агаарын цахилгаан дамжуулах шугам сүлжээний ажлын төсөвт өртгийн 10,402,720.0 мянган төгрөгийг Монгол Улсын Засгийн газар санхүүжүүлэхээр заасан боловч 2025, 2026 оны Улсын төсвөөс санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгаагүй байгаа нь төсөл, хөтөлбөрийг зээлийн гэрээнд заасан хугацаанд бүрэн хэрэгжүүлэхгүй байх, төсөл дуусах хугацааг дахин сунгах, үргүй зардал нэмэгдэх эрсдэл үүсэхээр байна.

Бусад асуудал

Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу аудитын мөрөөр хяналт тавих арга хэмжээ буюу өмнөх аудитаар өгсөн аудитын шийдвэрт дурдсан асуудлыг шалгагдагч байгууллага хэрхэн хэрэгжүүлж, шийдвэрлэснийг аудитор хянаж, үнэлэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	328,007,764.71	411,388,234.47
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	316,049,430.47	393,996,190.32
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	316,049,430.47	393,996,190.32
31210	Төгрөг	243,211.91	24,878,724.37
31211	Төрийн сангийн харилцах	243,211.91	24,878,724.37
31220	Гадаад валют	315,806,218.56	369,117,465.95
31221	Төрийн сангийн харилцах	315,806,218.56	369,117,465.95
33	АВЛАГА	-	15,680,386.62
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	12,380,386.62
33510	Байгууллагаас авах авлага	-	3,300,000.00
34	УРЬДЧИЛГАА	6,750,000.00	-
34600	Урьдчилж гарсан зардал	6,750,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	5,208,334.24	1,711,657.53
35440	Түлш, шатах тослох материал	1,250,334.24	1,711,657.53
35470	Бусад хангамжийн материал	3,958,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	287,447,912.21	270,639,839.63
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	287,447,912.21	270,639,839.63
39200	Биет хөрөнгө	280,022,912.21	265,194,839.63
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,591,590.66	98,591,590.66
39204	Хуримтлагдсан элэгдэл	(8,215,965.90)	(24,647,897.70)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	64,669,310.00	77,826,735.50
39206	Хуримтлагдсан элэгдэл	(3,836,774.41)	(20,514,060.07)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	132,176,190.00	151,072,013.40
39208	Хуримтлагдсан элэгдэл	(3,361,438.14)	(17,133,542.16)
39300	Биет бус хөрөнгө	7,425,000.00	5,445,000.00
39301	Програм хангамж	7,920,000.00	7,920,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(495,000.00)	(2,475,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	615,455,676.92	682,028,074.10
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	19,295,293.15	8,424,770.96
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	19,295,293.15	8,424,770.96
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	260,056.31	3,551,902.93
41361	Байгууллагад төлөх өглөг	1,993,000.00	4,826,577.00
41363	Татварын өглөг	9,831,065.03	46,291.03
41364	НДШ-ийн өглөг	7,211,171.81	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	596,160,383.77	673,603,303.14
51200	Хуримтлагдсан үр дүн	596,160,383.77	673,603,303.14
51210	Өмнөх үеийн үр дүн	-	596,160,383.77
51220	Тайлант үеийн үр дүн	596,160,383.77	77,442,919.37
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	615,455,676.92	682,028,074.10

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,293,593,609.67	1,245,900,050.74
1200043	Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	1,194,002,019.01	1,140,337,941.84
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	98,591,590.66	-
120009	Бусад орлого	1,000,000.00	20,093,248.90
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	85,468,860.00
131001	Хандив тусламж /гадаад/	-	85,468,860.00
2	НИЙТ ЗАРДЛЫН ДҮН	700,979,055.45	1,172,209,438.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	700,979,055.45	1,172,209,438.06
2101	Цалин хөлс нэмэгдэл урамшуулал	351,928,975.06	290,026,735.24
210101	Үндсэн цалин	342,149,169.87	290,026,735.24
210102	Нэмэгдэл	9,779,805.19	-
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	41,697,008.98	32,534,521.93
210201	Нийгмийн даатгалын шимтгэл	41,697,008.98	32,534,521.93
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	117,230,220.48	140,113,746.73
210301	Гэрэл, цахилгаан	428,725.00	-
210304	Байрны түрээс	116,801,495.48	140,113,746.73
2104	Хангамж, бараа материалын зардал	37,530,686.06	34,852,563.57
210401	Бичиг хэргийн материал	3,770,377.27	7,253,610.45
210402	Тээвэр, шатахуун	15,224,369.76	10,281,163.71
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	4,955,025.03	9,732,879.41
210404	Ном, хэвлэл	268,250.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	13,312,664.00	7,584,910.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,140,331.82	43,991,114.36
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	3,537,600.00
210604	Урсгал засвар	47,140,331.82	40,453,514.36
2107	Томилолт, зочны зардал	51,909,754.60	105,041,612.00
210701	Гадаад албан томилолт	26,103,608.60	60,429,860.00
210702	Дотоод томилолтын зардал	25,806,146.00	44,611,752.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	37,170,900.00	474,324,872.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	34,920,900.00	431,533,739.76
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	8,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,250,000.00	11,128,304.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	598,644.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	22,542,185.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,371,178.45	51,324,271.47
210902	Бараа үйлчилгээний бусад зардал	462,000.00	2,462,950.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	15,909,178.45	48,861,321.47
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	592,614,554.22	73,690,612.68
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	3,545,829.55	4,087,540.61
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	3,545,829.55	4,087,540.61
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	335,233.92
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	335,233.92
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	3,545,829.55	3,752,306.69
7	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	596,160,383.77	77,442,919.37

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	1,195,002,019.01	85,468,860.00
1200044	Гадаад эх үүсвэрээс санхүүжих	1,194,002,019.01	-
120009	Бусад орлого	1,000,000.00	-
122	Тусламжийн орлого	-	
122002	Хандив тусламж /гадаад/	-	85,468,860.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	882,498,418.09	1,139,652,348.68
21	УРСГАЛ ЗАРДАЛ	882,498,418.09	1,139,652,348.68
210	Бараа ажил үйлчилгээний зардал	882,498,419.09	1,139,652,348.68
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	315,490,131.14	312,354,509.69
210101	Үндсэн цалин	315,490,131.14	312,354,509.69
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	34,853,756.17	36,291,233.28
210201	Тэтгэврийн даатгалын зардал	23,700,554.20	24,895,042.89
210202	Тэтгэмжийн даатгалын зардал	2,788,300.50	3,539,702.72
210203	ҮОМШӨ-ний даатгалын зардал	1,394,150.24	1,229,714.22
210204	Ажилгүйдлийн даатгалын зардал	1,394,150.24	1,229,714.22
210205	Эрүүл мэндийн даатгалын зардал	5,576,600.99	5,397,059.23
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	115,237,220.48	138,056,746.73
210301	Гэрэл, цахилгаан	428,725.00	12,690,746.73
210302	Байрны түрээс	114,808,495.48	125,366,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	31,948,320.30	30,579,309.86
210401	Бичиг хэргийн материал	3,271,000.00	7,253,610.45
210402	Тээвэр, шатахуун	16,474,704.00	10,742,487.00
210403	Шуудан холбоо интернетийн төлбөр	4,955,025.03	8,956,302.41
210404	Ном, хэвлэл	270,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,977,591.27	3,626,910.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	248,276,531.82	43,991,114.36
210601	Багаж, техник, хэрэгсэл	93,649,700.00	-
210602	Тавилга	99,841,700.00	3,537,600.00
210604	Урсгал засвар	54,785,131.82	40,453,514.36
2107	Томилолт, зочны зардал	51,909,754.60	105,041,612.00
210701	Гадаад албан томилолт	26,103,608.60	60,429,860.00
210702	Дотоод томилолтын зардал	25,806,146.00	44,611,752.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	84,320,703.58	470,874,872.76
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	75,320,703.58	432,154,383.76
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	8,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	9,000,000.00	4,378,304.00
210804	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	25,842,185.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	462,000.00	2,462,950.00
210902	Бараа үйлчилгээний бусад зардал	462,000.00	2,462,950.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	312,503,600.92	(1,054,183,488.68)
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	-	11,960,000.00
22	Хөрөнгийн зардал	-	11,960,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	11,960,000.00
223001	Бусад хөрөнгө	-	11,960,000.00

225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	(11,960,000.00)
7	САНХҮҮГИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
14	Бусад эх үүсвэр	3,545,829.55	1,144,425,482.45
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	3,545,829.55	4,087,540.61
145102	Бусад засгийн газрын гадаад төслийн зээл шинээр авах	-	1,140,337,941.84
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	335,233.92
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	335,233.92
8	САНХҮҮГИЙН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	3,545,829.55	1,144,090,248.53
9	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	316,049,430.47	77,946,759.85
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	316,049,430.47
100	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	316,049,430.47	393,996,190.32

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	596,160,383.77	596,160,383.77
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	596,160,383.77	596,160,383.77
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	596,160,383.77	596,160,383.77
Тайлант үеийн үр дүн	77,442,919.37	77,442,919.37
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	673,603,303.14	673,603,303.14

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,775,400,000.00	1,151,612,348.68	3,623,787,651.32	24.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,041,700,000.00	1,151,612,348.68	890,087,651.32	56.4
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,041,700,000.00	1,151,612,348.68	890,087,651.32	56.4
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	316,000,000.00	312,354,509.69	3,645,490.31	98.8
210101	Үндсэн цалин	316,000,000.00	312,354,509.69	3,645,490.31	98.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,900,000.00	36,291,233.28	3,608,766.72	91.0
210201	Тэтгэврийн даатгал	26,860,000.00	24,895,042.89	1,964,957.11	92.7
210202	Тэтгэмжийн даатгал	3,560,000.00	3,539,702.72	20,297.28	99.4
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,580,000.00	1,229,714.22	350,285.78	77.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,580,000.00	1,229,714.22	350,285.78	77.8
210205	Эрүүл мэндийн даатгал	6,320,000.00	5,397,059.23	922,940.77	85.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	138,100,000.00	138,056,746.73	43,253.27	100.0
210301	Гэрэл, цахилгаан	12,700,000.00	12,690,746.73	9,253.27	99.9
210304	Байрны түрээс	125,400,000.00	125,366,000.00	34,000.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	33,550,000.00	31,789,309.86	1,760,690.14	94.8
210401	Бичиг хэрэг	8,200,000.00	7,253,610.45	946,389.55	88.5
210402	Тээвэр, шатахуун	10,750,000.00	10,742,487.00	7,513.00	99.9
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,600,000.00	8,956,302.41	643,697.59	93.3
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,000,000.00	4,836,910.00	163,090.00	96.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	57,650,000.00	54,741,114.36	2,908,885.64	95.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,750,000.00	10,750,000.00	-	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,600,000.00	3,537,600.00	62,400.00	98.3
210604	Урсгал засвар	43,300,000.00	40,453,514.36	2,846,485.64	93.4
2107	Томилолт, зочны зардал	115,500,000.00	105,041,612.00	10,458,388.00	90.9
210701	Гадаад албан томилолт	60,500,000.00	60,429,860.00	70,140.00	99.9
210702	Дотоод албан томилолт	55,000,000.00	44,611,752.00	10,388,248.00	81.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,337,000,000.00	470,874,872.76	866,125,127.24	35.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,297,100,000.00	432,154,383.76	864,945,616.24	33.3
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	8,500,000.00	8,500,000.00	-	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	4,400,000.00	4,378,304.00	21,696.00	99.5
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	27,000,000.00	25,842,185.00	1,157,815.00	95.7
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	2,462,950.00	1,537,050.00	61.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,000,000.00	2,462,950.00	1,537,050.00	61.6
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,733,700,000.00	-	2,733,700,000.00	-
220001	Барилга байгууламж	2,733,700,000.00	-	2,733,700,000.00	-
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,775,400,000.00	1,225,806,801.84	3,549,593,198.16	25.7
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл	1,175,700,000.00	1,140,337,941.84	35,362,058.16	97.1
232002	Гадаад тусламжаар хэрэгжүүлэх ажил	3,599,700,000.00	85,468,860.00	3,514,231,140.00	2.4

Хилийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой худалдааг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

	Төсвийн гүйцэтгэлийн тохируулга		3,752,306.69		
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		319,801,737.16		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		393,996,190.32		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	10	6	4	40.0
620001	Удирдах ажилтан	1	1	0	-
620002	Гүйцэтгэх ажилтан	9	5	4	44.0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсөл хэрэгжүүлэх нэгж, түүний үйл ажиллагаа

Монгол улсын Засгийн Газар болон Азийн хөгжлийн банкны хооронд 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан хөнгөлөлттэй зээлийн 100,000.0 мянган ам.долларын санхүүжилтийн гэрээний дагуу Хилийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой худалдааг дэмжих төсөл нь 2030 оны 06 дугаар сарын 30-д дуусахаар төлөвлөн хэрэгжүүлж байна.

Хилийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой худалдааг дэмжих төслийн зорилгыг Монгол Улсын хилийн боомтуудын үйл ажиллагааны үр ашиг, уян хатан байдал, бараа, хүн амын шилжилт хөдөлгөөний аюулгүй байдлыг дээшлүүлэхэд оршино гэж тодорхойлсон байна. Дараах зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.

1. Үр ашигтай, уур амьсгалд тэсвэртэй хилийн байгууламжийг хөгжүүлэх.

Бүтээгдэхүүний үр дүнд уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй байдлыг сайжруулах, ачаа, зорчигч тээвэрлэх чадварыг нэмэгдүүлэх, түгжрэл, боловсруулах хугацааг багасгах, аялал жуулчлалыг нэмэгдүүлэх зорилгоор дор хаяж гурван хилийн боомтын дэд төслүүд багтана: Үүнд:

- Хилийн боомтын барилга байгууламж, ажилтнуудын орон сууцыг шинэчлэх, зорчигч болон ачаа тээврийн замыг өргөтгөх болон туслах дэд бүтцийг (ус, дулаан, эрчим хүч, харилцаа холбоо) хангах;
- Уур амьсгалд дасан зохицох арга хэмжээг хэрэгжүүлэх;
- Ухаалаг хилийн шалгалт, илрүүлэх төхөөрөмжөөр хангах. /Энэхүү загварт ирээдүйн тээвэр, логистикийн хэрэгцээг тусгаж, боломжтой бол тогтвортой барилгын материал, эрчим хүчний хэмнэлттэй шийдэл, эмэгтэйчүүд, хүүхдүүд, өндөр настан эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг хангах онцлог шинж чанарууд.

2. Хил дээр нэг эрүүл мэндийн зохицуулалт бий болгох.

Энэхүү бүтээгдэхүүн нь мал, амьтны халдварт өвчин, түүнчлэн хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнтэй холбоотой биологийн халдварын аюулаас урьдчилан сэргийлэх, тандалт, илрүүлэх, хариу арга хэмжээ авах замаар эрүүл мэндийн аюулгүй байдлыг сайжруулах зорилгоор дор хаяж хоёр хилийн боомтын дэд төслүүдийг боловсруулахад Азийн хөгжлийн сангийн 13 сэдэвчилсэн сангийн буцалтгүй тусламжийн эх үүсвэрийг ашиглана. Үр дүн:

- Илрүүлэх, тандалтын тоног төхөөрөмж зэрэг сонгогдсон хилийн боомтод нэг эрүүл мэндийн байгууламж барих, ургамлын хортон шавж, амьтны өвчин, хүнсний аюулгүй байдлын стандартыг шалгах лаборатори, шинжилгээ хийх, зөвлөгөө өгөх, хүмүүсийг тусгаарлах эмнэлгийн байгууламж;
- Биологийн аюулд бэлэн байх, хариу арга хэмжээ авах, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдал, анхны тусламж үзүүлэх, хүний наймаа, бэлгийн мөлжлөгтэй холбоотой эрсдэлтэй холбоотой хилийн ажилтнуудын чадавхыг сургалт, загварчлалын дасгалаар сайжруулах;
- Монгол Улсын Барилга, хот байгуулалтад зориулсан ажлын түвшний гамшиг, онцгой байдлын зохицуулалт, хариу арга хэмжээний төлөвлөгөө, үйл ажиллагааны журам, сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх.

3. Худалдааг хөнгөвчлөх системийг сайжруулах.

- Гарсан бүтээгдэхүүн нь үндэсний нэг цонхны үйлчилгээг бүрэн хэмжээгээр хэрэгжүүлэх;
- Монгол Улсын Гаалийн ерөнхий газрын эрсдэлийн удирдлагын тогтолцоо, үндэсний нэг цонхны үйлчилгээний хүрээнд эрсдэлийн удирдлагын модулийг боловсруулж

хэрэгжүүлэх, түүнчлэн үйл ажиллагааны горимыг дэмжих замаар Монгол улсын бүх хилийн боомтод сайжруулсан, нэгдсэн шийдвэр гаргахад зориулсан эрсдэлийн удирдлагын нийтлэг модулийг хэрэгжүүлэх замаар хилийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх;

- Худалдааны гол түншүүдтэй хил дамнасан цаасгүй худалдааны баримт бичгийг солилцох зорилгоор үндэсний нэг цонхны үйлчилгээний хүрээнд программуудыг боловсруулах;
- Нэг эрүүл мэнд, хилийн нэгдсэн удирдлага, ачааны машины удирдлага эсвэл логистикийн систем зэрэг өгөгдөл хуваалцах, зохицуулалтын механизм, үндэсний нэг цонхны үйлчилгээний интеграцлалыг хөгжүүлэх;
- Цаасгүй худалдаанд орон нутгийн жижиг худалдаачид болон БЖДҮ-ийн чадавхыг бэхжүүлэх, ялангуяа эдийн засгийн боломжууд өргөжиж байгаа үед нэмүү өртгийн сүлжээнд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх.

3.2 Төсөл хэрэгжүүлэх нэгжийн гадаад, дотоод орчин

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ыг мөрдлөг болгодог.

Хилийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой худалдааг дэмжих төсөл нь Төсвийн тухай хууль, Өрийн удирдлагын тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр хийх тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Барилгын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсөл хэрэгжүүлэгч нэгжийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”,
- Сангийн сайдын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн 174 дүгээр тушаалаар баталсан “Нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжид шилжихэд мөрдөх түр журам”.

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2-т “Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн удирдлагын талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: ... 14.2.10-т “Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх” гэж заасны дагуу тус төсөл хэрэгжүүлэгч нэгжид Сангийн яамны Дотоод аудит, санхүүгийн хяналт, шалгалт, үнэлгээний газраас дотоод хяналтыг хэрэгжүүлсэн байна.

Тус газраас төсөл хэрэгжүүлэгч нэгжийн 2025 оны үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнг төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем дээр үнэлгээ хийж, нийт үнэлгээг 69.5 хувьтай баталгаажуулсан байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудиторын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хилийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой худалдааг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Төсөл хэрэгжүүлэгч нэгж нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлагналд мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй боловч Төсвийн тухай хууль болон УСНББОУС-д нийцүүлэн боловсруулсан Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар баталсан “Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам”-ын 21 дүгээр бүлэг “Гадаад зээл, тусламжийн бүртгэл”, Сангийн сайдын 2021 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн 04 дүгээр тушаалаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгөөр санхүүжигдэх төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг тус тус мөрдөж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Хилийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой худалдааг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө, өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 66,572.4 мянган төгрөгөөр буюу 10.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	316,049.4	393,996.2	77,946.8
Авлага	-	15,680.4	15,680.4
Урьдчилгаа	6,750.0	-	(6,750.0)
Бараа материал	5,208.4	1,711.7	(3,496.6)
Үндсэн хөрөнгө	287,447.9	270,639.8	(16,808.1)
Нийт хөрөнгө	615,455.7	682,028.1	66,572.4
Богино хугацаат өр төлбөр	19,295.3	8,424.8	(10,870.5)
Хуримтлагдсан үр дүн	596,160.4	673,603.3	77,442.9
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	615,455.7	682,028.1	66,572.4

Дээрх үзүүлэлтээс харахад дараах данстуудад нөлөө бүхий өөрчлөлт орсон байна. Тухайлбал,

-Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 77,946.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь Азийн хөгжлийн банкны зээл, тусламжийн эх үүсвэрээс нийт 1,225,806.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, үйл ажиллагааны зардалд 1,151,612.3 мянган төгрөгийг зарцуулж, 3,752.3 мянган төгрөгийн валютын ханшийн зөрүүний олзыг хүлээн зөвшөөрч бүртгэсэнтэй холбоотой байна.

-Үндсэн хөрөнгийн үлдэгдэл 16,808.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд тооцсон 48,861.3 мянган төгрөгөөр хөрөнгийн элэгдлийн зардалтай холбоотой байна. Тайлант

онд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2025 оны А-1/2337 дугаар албан бичгийн дагуу Хилийн боомтын захиргаанаас 16 нэр төрлийн 22,423.5 мянган төгрөгийн өртөгтэй, 2,330.3 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй хөрөнгийг балансаас балансад шилжүүлэн авсан, 11,960.0 мянган төгрөгийн хөрөнгийг төслийн санхүүжилтээр худалдан авснаар нэмэгдсэн байна.

-Богино хугацаат өр төлбөрийн үлдэгдэл 10,870.5 мянган төгрөгөөр буурч, жилийн эцсийн байдлаар ажилчдад төлөх 3,551.9 мянган төгрөгийн, 3 харилцагчтай холбоотой 4,872.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

-Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл өмнөх оноос 77,442.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант оны үйл ажиллагааны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Хилийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой худалдааг дэмжих төсөл нь 2025 онд хөтөлбөр, арга хэмжээг гадаадын зээлийн эх үүсвэрээс 1,174,700.0 мянган төгрөг, хандив тусламжаас 3,599,700.0 мянган төгрөг нийт 4,774,400.0 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, хөрөнгө оруулалтын зардалд 3,599,700.0 мянган төгрөг, урсгал зардалд 789,700.0 мянган төгрөг, гадаадын төслийн зээлээр санхүүжих зардалд 385,000.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөж батлуулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсөв захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг гадаадын зээлийн эх үүсвэрээс 1,140,337.9 мянган төгрөг, хандив тусламжаас 85,468.9 мянган төгрөг, нийт 1,225,806.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, 1,151,612.3 зарцуулж, нийт гүйцэтгэл 93.9 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувь/
1	70207 Гадаадын зээл тусламжаар хэрэгжих төсөл хөтөлбөр	4,775,400.0	1,225,806.8	3,549,593.2	25.7
1.1	80104- Гадаад зээлээр хэрэгжүүлэх ажил	1,175,700.0	1,140,337.9	35,362.1	97.1
1.2	80105- Гадаад тусламжаар хэрэгжүүлэх ажил	3,599,700.0	85,468.9	3,514,231.1	2.4

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэхэд гадаад томилолтыг 60,500.0 мянган төгрөгөөр төсөвлөж 60,429.7 мянган төгрөгийн гүйцэтгэлтэй байгаагаас тухайн зардалтай холбоотой анхан шатны баримтын бүрдэлгүй 32,790.0 мянган төгрөгийн ажил, гүйлгээг санхүүгийн тайланд бүртгэсэн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

3.5.3 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Хилийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой худалдааг дэмжих төсөл нь 2025 онд 9 ажил хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 84.0 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Хүснэгт 3. Төслийн зорилтот түвшин, гүйцэтгэл

№	Төслийн хүрэх үр дүн	Тайлант жилийн /хувиар/		
		төлөвлөгөө түвшин	хэрэгжилт түвшин	биелэлт
1	ҮР АШИГТАЙ, УУР АМЬСГАЛД ТЭСВЭРТЭЙ ХИЛИЙН БАЙГУУЛАМЖУУД БАРИХ			
1.1	Хавирга боомтын барилгын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж, барааны худалдан авалтыг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах,	20.0	10.0	50.0
1.2	Булганы боомтын өргөтгөлийн барилга барих газартай холбоотой асуудлыг орон нутгийн удирдлагатай шийдэх, өргөтгөлийн ажлын зураг төсөл, төсвийг дуусгах, Барилгын хөгжлийн газраар батлуулах,	10.0	8.0	80.0
1.3	Цагааннуур боомтын барилга байгууламжийг барих газартай холбоотой асуудлыг орон нутгийн удирдлагатай бүрэн шийдсэн, Барилгын хөгжлийн газраар баталгаажсан боомтын барилгын ажлын бүрэн зураг төсөл, төсвийг АХБ-д илгээх,	10.0	5.0	50.0
2	ХИЛ ДЭЭРХ “НЭГ ЭРҮҮЛ МЭНД”-ИЙН УЯЛДАА, ЗОХИЦУУЛАЛТЫГ БИЙ БОЛГОХ			
2.1	Хавирга, Булган хилийн боомтод (ВСР)-д “Нэг эрүүл мэнд” (One Health) чиглэлийн био аюулгүй ажиллагааны II шатны лабораторийн барилгын зургийн даалгаврын төслийг боловсруулах, холбогдох мэргэжилтнүүдээр хянуулах,	10.0	10.0	100.0
2.2	Төсөлд хамрагдсан боомтуудын “Нэг эрүүл мэнд”-ийн лабораторид шаардлагатай бараа, тоног төхөөрөмжийн жагсаалт, тоо хэмжээг гаргах, техникийн үзүүлэлтийг тодорхойлох,	10.0	10.0	100.0
2.3	“Нэг эрүүл мэнд”-ийн техникийн гадаад, дотоод зөвлөхийн ажлын даалгаврын чиг үүргийг боловсруулах, сонгон шалгаруулах, ажлын даалгаварт тусгагдсан ажлуудыг гүйцэтгүүлэх,	20.0	20.0	100.0
2.4	Төслийн баримт бичигт дурдсан болон Нэг эрүүл мэндийн дотоодын зөвлөхийн ажлын даалгаварт тусгагдсан үйл ажиллагааг хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулан, төслийн захирлаар батлуулан, хэрэгжүүлж байх,	20.0	20.0	100.0
2.5	Төсөлд хамрагдсан боомтуудын хилийн хяналтын ажилтнууд, боомтыг хариуцсан аймаг болон үндэсний түвшний албан хаагчдын хүний наймаа болон жендерт суурилсан хүчирхийллийн талаарх мэдлэг дээшлүүлсэн байх,	20.0	20.0	100.0
3	ХУДАЛДААГ ХӨНГӨВЧЛӨХ СИСТЕМИЙГ САЙЖРУУЛАХ			
3.1	Үндэсний цахим нэг цонх гаалийн эрсдэлийн удирдлагын систем хөгжүүлэх болон хэрэгжүүлэх үйлчилгээг нэвтрүүлэх	5.0	2.0	40.0
Дундаж хувиар илэрхийлсэн		13.9	11.7	84.0

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн Удирдах хорооны 2025 оны А/01 дүгээр тогтоолын 1дүгээр хавсралтаар “төслийн 2025 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-г баталж, 18 арга хэмжээнд 20,617.8 мянган төгрөгийг зарцуулахаар баталсан байна.

Тайлант онд 18 ажил, үйлчилгээ төлөвлөснөөс бусад төсөл хөтөлбөрийн нэгжийн ажил, үйлчилгээтэй давхцаж байгаа 4 ажил, үйлчилгээг цуцлах санал боловсруулж, 5 ажил хойшлогдож, 9 худалдан авах ажиллагааг зохион байгуулж, хэрэгжилт 84.0 хувьтай байна.

4.АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Хилийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой худалдааг дэмжих төслийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсөл хэрэгжүүлэх нэгж түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн жолоочийн шатахууны тооцоо бодоогүй, бараа материалыг шууд зардалд тайлагнасан асуудалд зөвлөмж өгөхөөр тусгасан болно.

Аудитыг Бэйкер Тилли Далайван Аудит ХХК-ийн ахлах аудитор Л.Номин, аудиторын туслах С.Булганчимэг, Б.Хонгорзул нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Болормаа, компанийн ерөнхий захирал Ц.Жигдэн нар анхан шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, Үндэсний аудитын газрын аудитор Г.Тэлмүүн, аудитын менежер П.Чанцалдулам, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар дараагийн шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Хилийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой худалдааг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 193 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн материаллаг байдлыг АДБОУС 2320-д заасны дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын эх сурвалжийг санхүүгийн үр дүнгийн тайлан суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,172,544.7 мянган төгрөгийн 1.5 хувиар тооцож 17,588.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд хязгаарласан 30 заалтуудыг хамруулан нарийвчилсан горим сорил хэрэгжүүлсэн, аудитаар зөрчил илрээгүй болно.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Илрүүлэлт: Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих 25 төрлийн 156 мэдээллээс байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хөтөлбөр зориулалт, хэмнэлт хэтрэлт гэсэн 3 мэдээллийг хугацаа хоцроосон, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, санхүүгийн тайланг мэдээлээгүй байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 588,207.6 мянган төгрөгийн 61 мэдээлэл байршуулахаас 160,114.1 мянган төгрөгийн 12 мэдээлэл байршуулаагүй, 5,100.0 мянган төгрөгийн 1 мэдээлэл хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл Шилэн дансны мэдээлэл 6.1.1-т “тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор”; 6.1.2-т “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор”; 6.1.4-т “жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор”, 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ”: 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалттай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих мэдээллийг байршуулаагүй зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 42,034.8 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт, 36,657.8 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 257,309.6 мянган төгрөгийн 5 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилтийг хянаж үнэлэхэд 54.4 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитаар өгсөн		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	2	42,034.8	-	4,864.7	14.1
Албан шаардлага	3	36,657.8	3	36,657.8	100.0
Зөвлөмж	5	257,309.6	3	141,204.0	54.9
Нийт дүн	10	336,002.2	6	182,726.5	54.4

Албан томилолтын зардлыг жишиг нормоос илүү тооцсон 3,948.0 мянган төгрөг, ажилд томилсон тухай тушаал шийдвэргүй, хөлсөөр ажиллах гэрээ хийгдээгүй нэр бүхий ажилтнуудад олгосон 33,222.1 мянган төгрөг, нийт 37,170.1 мянган төгрөгийн өмнөх аудитаар тогтоосон 2 төлбөрийн актыг бүрэн барагдуулаагүй асуудалд өмнөх хугацаанд ажиллаж байсан буруутай албан тушаалтныг тогтоож, сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлсийг нягтлан бодох бүртгэлийн холбогдох ангиллын дагуу бүртгээгүй, цалингийн зардалд буруу тайлагнасан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, дахин давтагдсан зөрчилд тайлант онд албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

- Төсөл хэрэгжүүлэгч нэгжийн баримт бичигт цахилгаан дамжуулах шугам сүлжээний барилга угсралтын ажлыг Монгол Улсын Засгийн газар хариуцах тухай заасан хэдий ч өнөөдрийн байдлаар барилга угсралтын ажил эхлээгүй, улсын төсөвт санхүүжилтэд тусгагдаагүй асуудлыг;
- Зураг төслийн өөрчлөлттэй холбоотой гарах нэмэлт ажлын гүйцэтгэл, зардал зэргийг дараагийн аудитаар анхаарах нь зүйтэй байна.

5.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13,030.4 мянган төгрөгийн 1 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулсан. Үүнд:

- Өмнөх оны аудит хийсэн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн эцсийн үлдэгдэл 2025 оны эхний үлдэгдлээс 13,030.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.

Дээрх алдаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална: "5.1.4.үнэн зөв байх" заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 74,489.4 мянган төгрөгийн 5 зөрчил² илэрсэнд 56,504.2 мянган төгрөгийн зөрчлийг таслан зогсоох 2 албан шаардлага, сахилгын шийтгэл ногдуулах 1 албан шаардлага хүргүүлж, 17,985.1 мянган төгрөгийн зөрчилд давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн 74,489.4 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон 17,588.2 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшнээс 56,901.2 мянган төгрөгөөр давсан тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Албан шаардлага

5.1.1 Илрүүлэлт: АНУ-ын Вашингтон хотноо Дэлхийн банк, валютын сангийн жилийн уулзалтад оролцохоор эрх бүхий 2 албан тушаалтны онгоцны тийзийн төлбөрт 32,790.0 мянган төгрөгийг албан ёсны урилга, дээд газрын тушаал шийдвэргүйгээр гадаад томилолтын зардлаас гаргасан бөгөөд ажлын тайлан, онгоцны тийзийг хавсаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална": "5.1.4.үнэн зөв байх", 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", 20 дугаар зүйлийн 20.2.9-д "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг санхүүгийн тайланд бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

5.1.2 Илрүүлэлт: Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр болох 23,714.3 мянган төгрөгийг нягтлан бодох бүртгэлийн холбогдох ангиллын дагуу бүртгээгүй, цалингийн зардалд буруу тайлагнасан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5.1.5-д "хариуцлагатай байх", Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана" 22.2.3-т "эдийн засгийн ангиллаар", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" заалттай нийцэхгүй, үнэлгээ ба хуваарилалт болон ангилал батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийг холбогдох ангиллын дагуу үнэн зөв бүртгээгүй зөрчлийг таслан зогсоож, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

5.1.3 Илрүүлэлт: Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн актыг барагдуулаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.3 “Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ.” заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актыг барагдуулаагүй, өмнөх жилд ажиллаж байсан буруутай албан тушаалтныг тогтоож, сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлээ.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

5.2.1 Бараа материалын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Жолоочийн шатахууны тооцоо бодоогүй, түлш шатахууныг худалдан авсан бөөн дүнгээр шууд зардалд тайлагнасан байна.

Энэ нь Сангийн сайдын 2017 оны "Маягт заавар батлах тухай" 347 тоот тушаалын 4-т Жолоочийн тооцооны хуудас хөтлөхдөө "Тухайн байгууллагын хөнгөн тэрэг нь ямар албан тушаалтны хэрэгцээнд үйлчилсэн талаарх гүйцэтгэлийг гаргахдаа жолоочийн тооцооны хуудсыг хэрэглэнэ. Хөнгөн тэрэг хэрэглэсэн албан тушаалтан хэдэн км явснаа хянаад гарын үсэг зурна. Тооцоог нягтлан бодогч хийж, нийт дүнгээр түлш, шатахууны хэмнэлт, хэтрэлтийг гаргана.", Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8.21-д "Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн байнгын системийг ашиглан бараа материалыг бүртгэнэ. Бараа материал олж бэлтгэх, хүлээн авах (а) бараа материалыг худалдан авсан үед өртгөөр нь: Дт Бараа материал /нэр төрлөөр/ Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Дансны өглөг/ Урьдчилж төлсөн тооцоо (д) бараа материалыг ажил, үйлчилгээнд зарцуулах үед: Дт Зардал /нэр төрлөөр/ Кт Бараа материал /нэр төрлөөр/" заалттай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Жолоочийн шатахууны зарцуулалтын тооцоог бодож, холбогдох журмын дагуу нягтлан бодох бүртгэлд бүртгэж, тайлагнаж байх.

Илрүүлэлт: Бараа материалын дансанд бүртгээгүй, шууд зардалд тайлагнасан дараах зөрчлүүд байна. Үүнд:

- Нэр бүхий бараа, хангамжийн /ханын шилэн самбар, дугуйтай цагаан самбар, баримт зүсэгч, баримт үдэгч, бичгийн цаас гэх мэт/ 3,705.0 мянган төгрөгийн материал;
- Үндсэн болон гэрээт ажилтанд 288.2 мянган төгрөгийн 8 ширхэг цамц, 176.0 мянган төгрөгийн 7 ширхэг хантааз, нийт 3,537.6 мянган төгрөгийн ажлын хувцас захиалгаар хийлгүүлэн хэрэглэж байгаа ажилтны нэр дээр карт хөтөлж бүртгээгүй.

Энэ нь Сангийн сайдын 2025 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/3 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 8 дугаар зүйлийн 8.21-д Төсвийн байгууллага нь нягтлан бодох бүртгэлийн байнгын системийг ашиглан бараа материалыг бүртгэнэ. Бараа материал олж бэлтгэх, хүлээн авах (а) бараа материалыг худалдан авсан үед өртгөөр нь: "Дт Бараа материал /нэр төрлөөр/ Кт Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө/ Дансны өглөг/ Урьдчилж төлсөн тооцоо (д) бараа материалыг ажил, үйлчилгээнд зарцуулах үед: Дт Зардал /нэр төрлөөр/ Кт Бараа материал /нэр төрлөөр/", 8.22-т "Байгууллага нормын хувцас, хэрэгслийг зардалд хүлээн зөвшөөрөхдөө ашиглалтад тавьж олгох үед, эсхүл ашиглалтаас хасах үед гэсэн хоёр хувилбарын аль тохиромжтойгоор бүртгэнэ. (а) нормын хувцас, хэрэгслийг ашиглалтад тавьж олгосон үед тайлант үеийн зардлаар хүлээн зөвшөөрөх тохиолдолд: Дт Зардал /нэр төрлөөр/, Кт Хангамжийн материал /нэр төрлөөр; /б) ашиглалтад тавьж олгосон нормын хувцас, хэрэгслийг хэрэглэж байгаа

ажилтны нэр дээр карт хөтлөх ба ашиглалтаас хасах үед зардлаар хүлээн зөвшөөрөх тохиолдолд: Дт Зардал /нэр төрлөөр/ Кт Хангамжийн материал /нэр төрлөөр/" заалттай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хангамжийн материалыг аккруэл сууриар бүртгэж, ашиглалтад байгаа хангамжийн материалыг бараа материал дансанд нь бүртгэж, үнэн зөв тайлагнаж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6 АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Өмнөх оны аудит хийсэн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн эцсийн үлдэгдэл санхүү байдлын тайлангийн эхний үлдэгдлээс 13,030.4 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан.	1	13,030.4			1	13,030.4	1	13,030.4				
Дүн	1	13,030.4			1	13,030.4	1	13,030.4				

6.2.Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага албан шаардлага		Хууль, хяналтад шилжүүлсэн	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтан	Тоо	Дүн
АНУ-ын Вашингтон хотноо Дэлхийн банк, валютын сангийн жилийн уулзалтад оролцохоор эрх бүхий 2 албан тушаалтны онгоцны тийзийн төлбөрт 32,790.0 мянган төгрөгийг албан ёсны урилга, дээд газрын тушаал шийдвэргүйгээр гадаад томилолтын зардлаас гаргасан бөгөөд ажлын тайлан, онгоцны тийз хавсаргаагүй байна.	1	32,790.0			1	32,790.0						
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр болох 23,714.3 мянган төгрөгийг нягтлан бодох бүртгэлийн холбогдох ангиллын дагуу бүртгээгүй, цалингийн зардалд буруу тайлагнасан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.	1	23,714.3			1	23,714.3						
Өмнөх оны аудитаар тогтоосон төлбөрийн актыг барагдуулаагүй байна.	1	-							1	-		

Хилийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой худалдааг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Жолоочийн шатахууны тооцоо бодоогүй, түлш шатахууныг худалдан авсан бөөн дүнгээр шууд зардалд тайлагнасан байна.	1	10,742.5					1	10,742.5				
Бараа материалын дансанд бүртгээгүй, шууд зардалд тайлагнасан дараах зөрчлүүд байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> Нэр бүхий бараа, хангамжийн /ханын шилэн самбар, дугуйтай цагаан самбар, баримт зүсэгч, баримт үдэгч, бичгийн цаас гэх мэт/ 3,705.0 мянган төгрөгийн материал; Үндсэн болон гэрээт ажилтанд 288.2 мянган төгрөгийн 8 ширхэг цамц, 176.0 мянган төгрөгийн 7 ширхэг хантааз, нийт 3,537.6 мянган төгрөгийн ажлын хувцас захиалгаар хийлгүүлэн хэрэглэж байгаа ажилтны нэр дээр карталж бүртгээгүй. 	1	7,242.6					1	7,242.6				
Дүн	5	74,489.4			2	56,504.3	2	17,985.1	1		-	

6.3.Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих 25 төрлийн 156 мэдээллээс байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хөтөлбөр зориулалт, хэмнэлт хэтрэлт гэсэн 3 мэдээллийг хугацаа хоцроосон, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, санхүүгийн тайланг мэдээлээгүй байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 588,207.6 мянган төгрөгийн 61 мэдээлэл байршуулахаас 160,114.1 мянган төгрөгийн 12 мэдээлэл байршуулаагүй, 5,100.0 мянган төгрөгийн 1 мэдээлэл хугацаа хоцроосон байна	1	165,214.1			1	165,214.1			
Дүн	1	165,214.1			1	165,214.1			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 1263/A0150061

Улаанбаатар хот

САГ-2026/71/НА-СТА-ТХН

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хилийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой худалдааг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

АНУ-ын Вашингтон хотноо Дэлхийн банк, валютын сангийн жилийн уулзалтад оролцохоор эрх бүхий 2 албан тушаалтны онгоцны тийзийн төлбөрт 32,789,960.00 /гучин хоёр сая долоон зуун наян есөн мянга есөн зуун жаран/ төгрөгийг албан ёсны урилга, дээд газрын тушаал шийдвэргүйгээр гадаад томилолтын зардлаас гаргасан бөгөөд ажлын тайлан, онгоцны тийз хавсаргаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно." 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.9-т "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.1-д "нягтлан бодох бүртгэлийг холбогдох стандарт, хууль тогтоомжийн дагуу зохих ёсоор хөтөлж, баталгаажуулаагүй" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг санхүүгийн тайланд бүртгэсэн зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдааг дэмжих төслийн захирал Б.Тавинжил, санхүүгийн мэргэжилтэн Д.Янжинсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Ц.ЖИГДЭН

9006109
ATA16037
9025081411

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z:\Alban Shaardlaga\2026\0410 SAG-8.Docx

1576181971



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 1262/АД150061

Улаанбаатар хот

САГ-2026/71/НА-СТА-ТХИ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хилийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой худалдааг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулбал зохих 25 төрлийн 156 мэдээллээс байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хөтөлбөр зориулалт, хэмнэлт хэтрэлт гэсэн 3 мэдээллийг хугацаа хоцроосон, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, санхүүгийн тайланг мэдээлээгүй байна. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 588,207,600.00 /таван зуун наян найман сая хоёр зуун долоон мянга зургаан зуун/ төгрөгийн 61 мэдээлэл байршуулахаас 160,114,100.00 /нэг зуун жаран сая нэг зуун арван дөрвөн мянга нэг зуун/ төгрөгийн 12 мэдээлэл байршуулаагүй, 5,100,000.00 /таван сая нэг зуун мянган/ төгрөгийн 1 мэдээлэл хугацаа хоцроосон байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1-д "тухайн жилийн төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөлтийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор"; 6.1.2-т "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор"; 6.1.4-т "жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, хагас жилийн тайланг 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор"; 6.4-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ."; 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр;" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулбал зохих мэдээллийг байршуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдааг дэмжих төслийн захирал Б.Тавинжил, санхүүгийн мэргэжилтэн Д.Янжинсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Ц.ЖИГДЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

ATA16087
9025081411

Z:\Alban Shaardlaga 2026\0410 SAG-8.Docx

1526181973



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 1261/АД/50061

Улаанбаатар хот

САГ - 2026/71/НА - СТА - ТХМ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хилийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой худалдааг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр болох 23,714,285.71 /хорин гурван сая долоон зуун арван дөрвөн мянга хоёр зуун наян таван төгрөг далан нэг мөнгө/ төгрөгийг нягтлан бодох бүртгэлийн холбогдох ангиллын дагуу бүртгээгүй, цалингийн зардалд буруу тайлагнасан, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 5.1.5-д "хариуцлагатай байх", 22 дугаар зүйлийн 22.1-т "Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана" 22.2.3-т "эдийн засгийн ангиллаар", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах," гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10-д "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Нягтлан бодох бүртгэлийг холбогдох ангиллын дагуу үнэн зөв бүртгээгүй зөрчлийг таслан зогсоож, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Хилийн үр ашгийг нэмэгдүүлэх тогтвортой худалдааг дэмжих төслийн захирал Б.Тавинжил, санхүүгийн мэргэжилтэн Д.Янжинсүрэн нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН:

БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Ц.ЖИГДЭН





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 10 өдөр

Дугаар 1260/A0150061

Улаанбаатар хот

САГ-2026/71/КА-СТА-ТХН

Сахилгын хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хилийн үр ашгийг нэмэгдүүлж тогтвортой худалдааг дэмжих төслийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Албан томилолтын зардлын жишиг нормоос илүү тооцсон 3,948,000.00 /Гурван сая есөн зуун дөчин найман мянган/ төгрөг, ажилд томилсон тухай тушаал шийдвэргүй, хөлсөөр ажиллах гэрээ хийгдээгүй, нэр бүхий ажилтнуудад олгосон 33,222,075.58 /гучин гурван сая хоёр зуун хорин хоёр мянга далан таван төгрөг тавин найман мөнгө/, нийт 37,170,075.58 /гучин долоон сая нэг зуун далан мянга далан таван төгрөг тавин найман мөнгө/ төгрөгийн өмнөх аудитаар тогтоосон актын төлбөрийг барагдуулаагүй байна.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.1-д "Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй нь, аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно" гэж заасан үндэслэл бүрдсэн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн , Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.2-т Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т заасан "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах, албан тушаалаас чөлөөлөх талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ." гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актыг барагдуулаагүй, тухай үед ажиллаж байсан буруутай албан тушаалтныг тогтоож, сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Хилийн үр ашгийг нэмэгдүүлж, тогтвортой худалдааг дэмжих төслийн захирал Б.Тавинжилд даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН:

БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

9006109
ATA11687
9025081411

Ц.НАРАНЧИМЭГ
П.ЧАНЦАЛДУЛАМ

Ц.ЖИГДЭН